



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2019 оны 08 сарын 14 өдөр

Дугаар 232

Улаанбаатар хот

Ердийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх
тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 6.2.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.4, Даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.2, 67 дугаар зүйлийн 67.1.1, 67.1.2, 67.1.3, 68 дугаар зүйлийн 68.1.1, 69 дүгээр зүйлийн 69.1.1, 73 дугаар зүйлийн 73.1, 73.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлтийг хангах хууль тогтоомжоор хүлээсэн үүрэг, Хорооноос өгсөн үүрэг даалгаврыг биелүүлж ажиллаагүй тул “Соёмбо даатгал” ХХК-ийн ердийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 6 сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлсүгэй.

2. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлтийг хангах, нөөц сан, дүрмийн сангийн хөрөнгийг хууль, журамд заасны дагуу нөхөж байршуулах, шинээр даатгалын гэрээ байгуулахгүй байх, даатгалын гэрээг шинэчлэхгүй, өөрчлөхгүй байх, их хэмжээний нөхөн төлбөрийг олгохгүй байх, нөхөн төлбөр, аж ахуй, үйл ажиллагааны зардлаас бусад хөрөнгө оруулалт хийхгүй байх болон компанийн хөрөнгийг бусдад шилжүүлэхгүй байхыг “Соёмбо даатгал” ХХК /Т.Одонтуяа/-д үүрэг болгосугай.

3. Түдгэлзүүлсэн хугацаанд гаргасан зөрчлөө арилгаж, өгсөн даалгаврыг биелүүлж энэ талаар Санхүүгийн зохицуулах хороонд мэдэгдээгүй тохиолдолд ердийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох хүртэл арга хэмжээ авахыг “Соёмбо даатгал” ХХК /Т.Одонтуяа/-д анхааруулсугай.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийт болон харьяалагдах татварын алба, Улсын бүртгэлийн ерөнхий газарт ажлын 10 хоногийн дотор мэдээлэхийг Ажлын алба /Б.Ариунаа/-нд даалгасугай.

ДАРГА

С.ДАВААСҮРЭН

E:\ajil 2019\Blank\Togtool.doc